



ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
81090 Улаанбаатар, Завхан аймаг  
Утас: 7575-1155, Факс: 7046-2550  
И-мэйл: zavkhan.zdtg@gmail.com

2024. 07. 05 № 6/648

таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

Г ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАРТ

Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд  
“Бэлчээр ашиглалт, усан хангамжийг сайжруулах  
зорилгоор худаг гаргана” гэсэн зорилтыг  
хэрэгжүүлэхээр аймгийн орон нутгийг хөгжүүлэх  
сангаас 84.2 (наян дөрвөн сая хоёр зуун мянга) сая  
төгрөгийг шийдвэрлэж, худаг гаргахаар тусгагдсан.

Иймд инженерийн хийцтэй гүн өрмийн худгийг  
Баянтэс, Баянхайрхан сумдад гаргах ажлын  
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг  
хуулийн дагуу зарлаж өгнө үү.

Ажлын даалгаврыг хавсралтаар хургуулж  
байна.

Хавсралт ... хуудастай.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА  Д.АЗЖАРГАЛ

3119090920

Тоот-А5-2024

**Гүн өрмийн худаг гаргах, худгийн барилга барих  
ажил гүйцэтгүүлэх техникийн тодорхойлолт**

Уг ажлыг мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

д/д	Үзүүлэлтүүд	Тендерт оролцогчийн санал
<b>1. Цооног өрөмдөх, цооногийг тоноглох</b>		
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтооно.	
1.2	Цооногийн ундарга 0,6-1,2 л/сек багагүй байна.	
1.3	Суултын яндангийн материал нь ган буюу ундын усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.4	Шүүрийн яндангийн хоолой нь ган буюу ундын усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.5	Ус өргөх яндангийн диаметр нь 32 мм, материал нь төмөр болон ундын усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хоолой ISO /хүйтний улиралд тэсвэртэй/ байна.	
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна.	
1.7	Тунгаагуурын гүн 2 м-ээс багагүй байна.	
1.8	Хударт шавхалт хийх хугацаа 72 цагаас багагүй байна.	
1.9	Усны чанарт дээж авч шинжилгээ хийлгэсэн байна.	
1.10	Худгийг түр хугацааны тагаар тоноглох шаардлагатай.	
<b>2. Мал услах онгоц, талбай барих</b>		
2.1	Мал услах онгоцны ус өгөх хоолой нь 60мм-ийн диаметртэй, гаднах ханаас 2м урттай гадагшилсан ган хоолой, уян хоолойг гаргана.	
2.2	Ундын ус авах хоолой нь 32мм диаметртэй ган хоолой, буюу уян хоолойг гаргана. /Ундын ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгоно/	
2.3	Босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1,0-1,5 м <sup>3</sup> -ээс багагүй багтаамжтай ган, эсвэл хүнсний зориулалттай хуванцар усны савтай дээрээ тагтай байна.	

	<p><b>Мал услах онгоцны:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Хэмжээ: 9м-ээс багагүй урттай, 400 мм-ийн голчтой хагас цилиндр хэлбэртэй шинээр хийсэн байна.</li> <li>Материал: Ган яндан хоолой буюу цутгамал төмөр бетон</li> <li>Онгоцыг худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 1м-ийн зайд байрлуулна.</li> <li>Онгоцны адагт ус юулэх жижиг нээлхий гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эрэгдэж хаадаг байхаар хийнэ.</li> <li>Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулж гагнаа.</li> <li>Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг мөлгөр болгож засна.</li> </ul>	
2.4	<p><b>Мал услах талбай.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Хэмжээ: Онгоцны нийт уртын дагуу 2 талдаа тус бүр 1 м-ийн өргөнтэй 10 см зузаантай 150 маркаас доошгүй бетон хийцтэй талбай байна.</li> <li>Мал услах талбай нь худгийн байшин болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юулэхэд тохиромжтой байршуулна.</li> </ul>	
<b>3. Худгийн насос, бага оврын генератор, цахилгааны утас, хянах самбар</b>		
3.1	Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байна./хүчин чадал ямар байхыг тодотгох/	
3.2	Цахилгааны утас: 3 фазын худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх янданд 2м тутамд хавчиж /туузаар ороож болохгүй/ тогтооно.	
3.3	Хянах самбар: Асаах, унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/, гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай байна.	
3.4	Бага оврын генератор: Бензинээр ажилладаг /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байна.	
<b>4. Худгийн ажлыг дуусгах, хүлээлгэн өгөх</b>		
4.1	Талбайг цэвэрлэнэ./Өрөмдлөгийн шlam, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт/	
4.2	Худаг, гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх талбайн сургалтыг худаг ашиглагч нарт хийнэ.	

4.3	Худгийн паспортыг бэлтгэж, баталгаажуулан сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгнө.	
4.4	Цахилгаан үүсгэвэр, насосны ашиглалтын болон аюулгүйн ажиллагааны зааврыг байршуулсан байна.	
4.5	Ус гарах боломж нэхцлийг бүрэн тооцож өрөмдлөг хийх ба ус гарахад учирч болох эрсдэлийг сонгон шалгаруулалтанд оролцсон компани хариуцна.	
4.6	Худгийн барилгыг ашиглагч байгууллага болох сумын Засаг даргын Тамгын газар хариуцан барина.	

Хянасан:  
ХБТХОХ-ийн дарга



—д. Азжаргал

**Боловсруулсан:**  
ХБТХОХ-ийн мэргэжилтэн Б.Баярмаа